

## Дархан-Уул аймаг Дархан сум

ТӨСЛИЙН НЭР	ТӨСЛИЙН НЭР: “БИД ТОГЛОХ ДУРТАЙ”
Төслийг санхүүжүүлэгч:	ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ИРГЭДИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧ
Төсөл хэрэгжүүлэгч:	Дархан-Уул, Дархан сум 12-р баг 22-р цэцэрлэг
Төслийн хугацаа:	2025 оны 2,3 улирал
Төсөлд хамрагдах хүрээ:	22-р цэцэрлэгийн 380 хүүхэд багачууд, 42 багш, ажилчид
Төслийн дүн:	12,190,000төгрөг
Хаяг:	Дархан-Уул аймгийн Дархан сумын 22-р цэцэрлэг
Утас:	Эрхлэгч-99026211

**НЭГ ТӨСЛИЙН ЗОРИЛГО:** Хүүхдийн сурч хөгжих таатай орчинг бүрдүүлэх, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчны стандарт MNS 6558:2015 хэрэгжүүлэн ажиллах, хүүхдэд ээлтэй тааламжтай хүртээмжтэй тоглох орчны эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангасан гадаад тоглоомын талбайг байгуулахад оршино.

### **ХОЁР: ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Боловсролын тухай хуулийн 42 Боловсролын байгууллагын сургалтын орчны талаар заасан ба БШУСайд болон Дархан-Уул аймгийн Засаг даргын хооронд 2021 онд засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний 3.8.6 “Суралцагчдад ээлтэй сургалтын орчин бүрдүүлж, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдлын батлагдсан стандартыг хангуулах, энэ чиглэлээр батлагдсан шийдвэр стандарт мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулах, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 1.2.1 “Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчлан сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт сургах зорилго бүхий биеийн тамир спортын хүртээмжтэй үйлчилгээг нэмэгдүүлнэ. “Эрүүл мэндийн дасгал хөдөлгөөн өрнүүлэх талбайн хүртээмжийг нэмэгдүүлэх” 1.3.3 “Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, сургуулийн орчныг сайжруулах” гэж заасан байдаг Тус цэцэрлэг нь 1989 оны 04-р дүгээр сарын 15-нд Зөвлөлт Холбоот Улсын тусламжтайгаар анх ашиглалтанд орсон 280 хүүхдийн хүчин чадалтай, Дархан сумын 12-р багийн нутаг дэвсгэрт байрладаг. Дархан сумын 12 багт 1252 өрх үүнээс ЕБС-д, 987 хүүхэд СӨББ-д 402 хүүхэд хамрагдаж байна. 12 дугаар багийн нийт хүн амын 35 хувь нь сургууль болон цэцэрлэгийн насны хүүхэд байна. 2025 оны байдлаар 12 дугаар багт 0-2 насны 456 хүүхэд, жил бүр энэ хэмжээний хүүхдүүд цэцэрлэгийн насанд хүрч байна. Тус цэцэрлэг нь 42 багш ажилтантай 380 хүүхэд хүлээн авч үйл ажиллагаагаа 36 дахь жилдээ явуулж байна.

## **ГУРАВ: ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ:**

Манай цэцэрлэг Дархан сумын 12 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг. Одоогийн байдлаар 380 хүүхэд хамрагдан суралцаж байна. Цэцэрлэгийн тоглоомын талбай нь тоглоомжилт муутай байгаа тоглоом нь олон жилийн эдэлгээнд орсон засвар авах боломжгүй байна. Цэцэрлэгийн гадна тоглоом дээр эргэн тойрны байрны хүүхдүүд бүгд тоглодог учраас эвдрэл гэмтэл их гарч байдаг.

Бага насны хүүхдийн гадна талбайн тоглоомын талбай нь хүүхдийг сурч хөгжих орчин болдог тул нэн чухал шаардлагатай, тулгамдсан асуудлуудын нэгд зүй ёсоор тооцогдож байгаа нь энэ төсөл хэрэгжүүлэх зайлшгүй үндэслэл болж байна.

## **ДӨРӨВ: ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ХУГАЦАА**

➤ Хугацаа: 2025 оны 2,3 улирал

## **ТАВ: SWOT ШИНЖИЛГЭЭ**

Сул тал	Давуу тал
Төрөөс боловсролд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ бага, хязгаарлагдмал байдаг. Гадна талбайн тоглоом болон гал тогоонд шаардлагатай техник хэрэгсэлийн хүрэлцээ хангамж дутмаг байна.	- Гадна тоглоом суурьлуулах бэлэн 100м <sup>2</sup> талбайтай
“О” Боломж (Opportunities)	“Т” Аюул (Threats)
Хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжилтийг дэмжих, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх цэцэрлэгийн хүүхдүүдийн чөлөөт цагаа боловсон өнгөрүүлэх боломжтой болно.	Зөвхөн цэцэрлэгийн хүүхдүүд тоглохоос гадна 12 багийн хүүхдүүд тоглох боломжтой орчин бүрдэнэ.



## **ЗУРГАА: ТӨСЛӨӨС ГАРАХ ҮР ДҮН**



Хүүхдийг гадаа тоглоомын талбайд тоглуулах нь хүүхдийнхээ энергийг зөв зарцуулах, задгай агаарт бусад хүүхдүүдтэй тоглох сайхан боломжыг олгодог. Тоглох нь хүүхдийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд тоглоомын талбайд хүүхдийн бие бялдар, асуудлыг шийдвэрлэх чадварыг хөгжүүлэх зорилготой дүүжин, гулсуур, авирах тоглоом гэх мэт төрөл бүрийн тоглоом байдаг. Хүүхэд тоглоомын талбайд бусад хүүхдүүдтэй хамт гүйх, тоглохоос эхлээд янз бүрийн хөгжилтэй зүйл хийж хөгжилдөж чаддаг. Гадаа тоглоомын талбайтай болсноор хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжилтийг дэмжих, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх цэцэрлэгийн цэцэрлэгийн хүүхдүүдийн чөлөөт цагаа боловсон өнгөрүүлэх боломжтой болно.

## Шаардлагатай тоглоомын хэрэгцээ

№	Шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн нэрс	Тоо ширхэг	Зориулалт, хэрэгцээ
1	Гулсуур бүхий гадаа тоглоомын талбайн иж бүрдэл тоглоом	1 ком	Хүүхэд тоглож байхдаа өөртэйгээ ижилсүүлж буй насанд хүрэгчийнхээ дүрээр бусадтай харьцах харилцаагаа тусгаж харуулдаг. Ингэснээр тоглоом гэдэг нь хүүхдийн өөрийгөө илэрхийлэх, өөртөө итгэх итгэлийг нь хөгжүүлж, тэсвэр тэвчээрт суралцуулах үүднээсээ өөр бусад шинэ чадварт суралцах үүд хаалгыг нээж өгнө. Тоглож байхдаа хүүхэд бусадтай багаар ажиллах, хуваалцах, бусадтай таарч тохиох эв эеэ олох арга барил, асуудлыг хэрхэн шийдвэрлэх тухайд мэдлэгтэй болдог
2	Бага насны хүүхдүүдэд зориулсан жижиг хэмжээтэй иж бүрдэл бүхий тоглоом	1ком	Хүүхдийг гадаа тоглуулах нь гар утас, телевиз, компьютерээс холдуулах, агаарт хөдөлгөөнтэй байлгах, бусад хүүхдүүдтэй, хүрээлэн буй орчинтой харьцах, нийгэмших, бие даах зэрэг эрүүл мэнд болоод хүмүүжлийн олон ач холбогдолтой билээ. Гэхдээ, хүүхдийг гадаа тоглуулна гэдэг зөвхөн гадаа гаргахын нэр биш юм. Хүүхэд тоглох орчин нөхцөл бүрдсэн байх учиртай. Үүнд: хүүхдийн өсөлт хөгжил, бие бялдарт сайнаар нөлөөлөх тоглоом, зөв төлөвлөлт бүхий орчны хүчин зүйлс хамаардаг.
3	Ногоон зүлэг		Хүүхдийг тоглоход аюулгүй байдлыг хангана. Хүүхдүүд айдасгүй баяр баясгалантай тоглох болно

## Гадаа талбайн тоглоомын үнийн судалгаа

№	Тоглоомын нэр	Тоо	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт үнэ /төг/	Зураг
1	Гулсуур (ногоон, улбар шар) авирах шат, хонгил, хашаа	1 багц	6.500.000	6.500.000	
2	Олон үйлдэлт тоглоом	1багц	3,190,000	3,190,000	
3	Ногоон зүлэг Гадна талбайн ногоон зүлэг м <sup>2</sup> -25.000	80м <sup>2</sup>	2.500.000	2.500.000	<p><b><u>Гадна ногоон зүлгийн онцлог</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Зүлэгний өргөн - 2м</li> <li>• Бороо, цас болон ус чөлөөтэй нэвтэрдэг бөгөөд угааж цэвэрлэх боломжтой</li> <li>• Цаг агаарын эсэргүүцэл: Дэвсгэр нь нарны гэрэл, бороо, хэт температурыг тэсвэрлэх чадвартай, цаг агаарын маш сайн тэсвэртэй тул хүрээлэн буй орчны нөлөөнд бага өртөмтгий болгодог.</li> <li>• Бактерийн эсрэг ба нянгийн эсрэг үйлчилгээтэй: Зүлэг нь бактерийн эсрэг ба нянгийн эсрэг үйлчилгээтэй тул цэвэр ариун байдал, эрүүл ахуйг сахихад хувь нэмэр оруулдаг тул хүүхдийн тоглоомын талбайд тохиромжтой.</li> </ul>

					 
	<b>Нийт:</b>			<b>12,190,000</b>	

ЭРХЛЭГЧ:



М.УРАНЧИМЭГ

Гадна талбайн тоглоом :

Гадна талбайн тоглоом “БУМАН ТОГЛООМ” ХХК

урт:6.6м

өргөн:3.3м

өндөр:3.3м



Гадна талбайн тоглоом: “СЭЦЭН ТӨГӨЛДӨР БУЯНТ” ХХК



660\*260\*360с  
立柱89



“Олон үйлдэлт тоглоом” RED star Улаан од ХХК



Урт 5метр 20    Өргөн 3 метр    Өндөр 3метр 60